



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/140

Улаанбаатар хот

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь заалт, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1 дэх зорилт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхдийн санал санаачлага, оролцоонд тулгуурлан хүүхдийн эрх, тэгш оролцоог дэмжих, шийдвэр гаргахад хүүхдийн дуу хоолойг хүргэх, нийгэмд эерэг нөлөөллийг бий болгох зорилгоор зохион байгуулагдаж буй хүүхдийн майхант зуслан цугларалтад оролцуулсугай.

2.Майхант зуслан цугларалтад оролцох дүүргийн Хүүхдийн зөвлөлийн гишүүн сурагчдын нэрсийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Уг арга хэмжээний зардал 1,800,000 (нэг сая найман зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гарган санхүүжүүлэхийг Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Майхант зуслан цугларалтад оролцогч хүүхдүүдийн аюулгүй байдлыг ханган оролцож, тайлагнахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтэс (Д.Оюунгэрэл)-д үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД